

АВЛИГАГҮЙ НИЙГМИЙГ БАЙГУУЛАХАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе!

Манай төр, засгийн өндөр, дээд албан тушаалтнууд, хувийн хэвшлийнхэн болон олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл цугларч Монгол Улсын хөгжлийг сааруулагч авлигатай эрс шийдвэртэй тэмцэх хүсэл зоригоо илэрхийлцгээж, шинэ тутам байгуулагдсан Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах бодлого, чиглэлээ ярилцаж буй нэн чухал мөчид олон нийтийг төлөөлөн оролцож, үг хэлж байгаадаа баяртай байна.

Хэдхэн хоногийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлд заасныг үндэслэн Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг баталж, түүний гишүүдийг томилохдоо надад уг Зөвлөлийн тэргүүнээр ажиллах итгэл хүлээлгэсэнд талархаж байна.

Авлигын эсрэг хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан Олон нийтийн зөвлөлийн ажиллах журамд зааснаар манай Зөвлөл авлигатай тэмцэхэд олон нийтийг төлөөлөн тогтмол үйл ажиллагаа явуулж, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байх үндсэн чиг үүрэгтэй болно.

Манай Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд нийгэмд бүтээлч, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, нэр хүнд сайтай, шударга, иргэний нийгмийнхнийг бүрнээ төлөөлж чадах хүмүүс орсон болохоор тэднээр дамжин авлигаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөлөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээ олон нийтийн дотор амжилттай хэрэгжихэд таатай нөлөө үзүүлнэ байх аа.

Юуны өмнө та бүхэнд Олон нийтийн зөвлөлийн хийх ажлын үндсэн чиглэлийг танилцуулах саналтай байна.

Авлигын эсрэг тэмцэхэд олон нийтийг төлөөлж ажиллах манай Зөвлөлийн үйл ажиллагаа авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиох ажилд олон түмнийг өргөн оролцуулан авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгэмд төлөвшүүлэхэд бүхэлдээ чиглэгдэнэ. Ингэснээр Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд зарим талын дэмжлэг болно гэж найдаж байна.

Олон нийтийн зөвлөлөөс хэрэгжүүлэх ажлын үндсэн чиглэл нь Авлигын эсрэг хуульд заасны дагуу авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын нөхцөл байдал, авлигын талаарх олон түмний санал, бодлыг судлан дүгнэлт

хийсний үндсэн дээр Авлигатай тэмцэх газар зөвлөмж өгөх, авлигын хор аюулыг олон түмэнд тайлбарлан таниулах гэсэн хоёр чиглэлтэй байх юм.

Зөвлөлийн ажиллах журамд зааснаар манай зөвлөл олон нийтийн харилцааны болон судалгаа, үнэлгээний гэсэн хоёр Дэд зөвлөлд хуваагдан ажиллах юм.

Олон нийтийн харилцааны дэд зөвлөл нь:

1. олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, авлигатай тэмцэх,
2. урьдчилан сэргийлэх асуудлаар хурал, зөвлөлгөөн, сургалт, сурталчилгаа зохион байгуулах,
3. авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллагуудын болон иргэдийн сайн дурын үйл ажиллагаа, хөдөлгөөнийг Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах,
4. авлигаас урьдчилан сэргийлэх талаар олон улсын байгууллага, гадаадын улс орон, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран нийслэл, бүс нутаг, орон нутгийн хэмжээнд төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах гэсэн дөрвөн чиглэлээр ажиллах болно.

Судалгаа, үнэлгээний дэд зөвлөл нь:

1. авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт болон авлигын нөхцөл байдлын талаар үнэлгээ хийж, түүнд дүгнэлт өгөх;
2. авлигын түвшин, хандлагын талаарх Авлигатай тэмцэх газрын судалгаанд санал, зөвлөмж өгөх;
3. авлигатай тэмцэх ажлын эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж гаргах;
4. авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон авлигатай хамтран тэмцэх талаар байгууллага, иргэдэд хандан уриалга гарган ажиллахад анхаарлаа хандуулахаар байгаа юм.

Энэ бүхнээс үзэхэд Зөвлөл нь Б.Дангаасүрэн даргын хэлсэнчлэн Авлигатай тэмцэх газрыг олон нийт буюу иргэний нийгмийнхний төлөөлөл болох төрийн бус байгууллагуудтай холбогч гүүр болж, нэлээд өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулахаар байгаа юм. Эдгээр ажил төр, захиргаа, хувийн хэвшлийн байгууллагуудын бодитой дэмжлэг, санхүүгийн зохих эх үүсвэр, олон нийт,

төрийн бус байгууллагуудын идэвхтэй оролцоогүйгээр амжилттай хэрэгжих бололцоогүй ээ.

Төрийн байгууллагаас иргэд, хуулийн этгээдэд үзүүлдэг төрийн үйлчилгээ болон тэдгээрийг зохицуулдаг хууль тогтоомжууд зэрэг зайлшгүй шаардлагатай мэдээллийг ил тод нээлттэй байлгах, зохион байгуулсан хурал, зөвлөлгөөн, сургалт сурталчилгааны арга хэмжээнд хамруулбал зохих хүмүүсээ заавал оролцуулах нь Зөвлөлийн үйл ажиллагаанд томоохон дэмжлэг болно.

Түүнчлэн авлигын түвшин, цар хүрээ, хандлагын дүн, төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээнд нухацтай дүгнэлт хийж авлига үүсгэдэг шалтгааныг таслан зогсоох тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох чиглэлээр гарсан олон нийтийн саналыг хүнд суртал чирэгдэл учруулалгүй шуурхай ажил хэрэг болгон шийдвэрлэх явдал чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Олон нийтийн зөвлөлөөс авлигын нөхцөл байдлыг судалж үнэлгээ өгөх, авлигын хор уршгийг сурталчлан урьдчилан сэргийлэх ажлыг бид авлигад их автагдсан гэж олон түмэн харддаг байгууллагуудаас эхэлнэ гэж бодож байна.

Ерөнхийлөгчийн үзэглэсэн олон нийтийн зөвлөл байгуулах тухай зарлигийн бэх бүрэн хатаагүй, үйл ажиллагааны маань эхлэл болох анхны хуралдаанаа ч хийж амжаагүй байгаа байгууллагынхаа мөрөөдөхөөс хэтрээгүй ажлын талаар дээр дурдсанаас илүүг нуршилгүй,

Энэ удаа олон түмнийхээ санал бодлыг төр, засагтаа хүргэх үүрэгтэй оролцогчийнхоо хувиар манай нийгэмд бугшсан авлигын байдал, түүнийг тойрсон нийгмийн сэтгэлзүйг үгээр холбон цухас зураглан өгүүлж, зарим санал хэлье.

Зөвхөн хуулийн дарангуйлал дор байж, хуулиар амьсгалан амьдарч ажиллах төрт ёс бүхий парламентын засаглалтай манай оронд тэгш байдал, шударга ёсны зарчмыг баримтлахаа тунхагласан 400 орчим хууль батлан мөрдүүлсэн ч тэдгээрийг хэрэгжүүлэх ажил ор нэр төдий байгаагаас хууль үйлчлэхээ больж, шударга ёс бүрнээ алдагдаж, нийгэм бүхэлдээ авлигачдын хүлээсэнд баглагдан буцаж гарахад бэрхтэй гүн хар ангал руу уначихаад байна.

Төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хүнд суртал, чирэгдлийг үүсгэж байгаа байдал нь олон түмний хүсэлтийг мөнгө, өнгө хоёроор шийддэг ёсыг бий болгож улмаар мөнгөтэй нь ямар ч асуудлыг гагцхүү авлигын замаар

шийдвэрлүүлэхдээ авлигад зарцуулсан зардлаа хийсэн бүтээсэн бүхэндээ шингээж эцсийн хэрэглэгчдэд дарамт болж, энэ нь бүх төрлийн бараа, үйлчилгээний үнийг байнга өсгөж байна.

Авлигач түшмэд, тэднийг өөгшүүлэгч бизнесмэнүүд хууль дүрмийнхээ дагуу шууд бүтчих ажлыг ч гагцхүү авлига авч, өгч байж шийдвэрлэх гэдэг болжээ. Үүнээс улбаалан Монголд авлигагүйгээр ямар ч ажил бүтэхгүй гэсэн нийгмийн сэтгэл зүй тогтож, төрийн байгууллагад энэ байдал газар авах хандлагатай байна.

Авлигын галд байнга тос нэмж байдаг гадна, дотны бизнесменүүдэд төрийн нэрийн өмнөөс зөвшөөрөл олгодог, хяналт тавьдаг зарим төрийн албан хаагчдын хууль бус байдал нь зарим талаараа төрийг хүчгүйдүүлж байна. Хүчгүй төрөөс тогтоосон хууль, дүрэм, журам хэрэгжихгүй ихэнхдээ замын дунд замхрах боллоо. Энэ нь нийгэмд зөв гэж бодсоноо хийх сонирхлыг нөхцөлдүүлж байна.

Энэхүү индэрийг ашиглан нэгэн зүйлийг хэлмээр байна. Авлигагүй нийгмийн байгуулахад иргэн бүрийн оролцоо ус, агаар мэт хэрэгтэй байна.

Үр хүүхдээ хуулийг санхин биелүүлдэг, шударга хүн болгон хүмүүжүүлэхээс бидний авлигатай тэмцэх тэмцэл эхэлнэ. Түүнчлэн өөрийн гүйцэтгэж байгаа ажил албаа ёс дүрмийнх нь дагуу хийж хуулийн хүрээнд өөрийн эрхийг эдлэж, бусдын эрхэнд үл халдах зарчмыг чанд баримтлахгүйгээр бид хөгжихгүй юм.

Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээ бага байгаа нь тэдний хэрэглээг хангаж чадахгүй байгаа нь тэд шударга ажиллахын оронд дутагдсан гачигдсанаа авлига авч нөхдгөөс авлига гарах шалтгаан болж байгааг анхаарах шаардлагатай байна.

Төрөөс албан хаагчдынхаа бодит хэрэглээг хангахуйц цалин өгснөөр авилга багасах учиртайг бид бүхэн бодох цаг болжээ.

Төр нь иргэдийнхээ амьдарлын баталгааг хангаж чадаагүй байж авлига авч болохгүй, авбал шийтгэнэ гэдэг бол цалинг бодит хэрэглээнд ойртуулсан хэмжээгээр нэмээгүй цагт “харганын ноос түүж эсгий хийх”-ийн үлгэр болох биш үү.

Авлигын нөхцөл байдал иймэрхүү болчихоод байгаа үед төрөө, улс орноо авлигын намаг балчигаас татаж гаргах зорилгоор Авлигын эсрэг хуулийг баталж, уг хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагыг байгуулсан. Энэхүү шийдвэрийг

төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгчид гаргасан нь дэвшил боловч эцсийн үр дүнг нь харахын тулд бүх шатны байгууллага, албан тушаалтны дэмжлэг туслалцаа маш их хэрэгтэй гэдгийг Та бүхэн ойлгож байгаа байх.

Авлигатай тэмцэх газарт ард түмэн ихээхэн найдлага тавьсан хэвээр байна. Энэхүү хүлээлт бол дан ганц энэ газрын бус төрийн өндөр, дээд албан тушаалтнууд Та бүхний авлигатай тэмцэх зорилго, тэмүүлэлийн хүлээлт юм шүү.

Хууль тогтоох байгууллага Авлигын эсрэг хуулиа батлаад 11 сар, хүчин төгөлдөр болоод 6 сар өнгөрөх хугацаанд уг газрын харъяалан мөрдөж шалгах хэргүүд зэрэг эрх зүйн орчин, зарцуулах төсөв зэргийг нь ойрын хугацаанд шийдвэрлэж энүү байгууллагын ажилд анхаарлаа хандуулах нь зүйтэй болов уу.

“Булгийн эх булингартай бол адагтаа тийм л байдаг” гэдэг шиг төрийн өндөр албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчлөөсөө татгалзахыг өөрсдөө үлгэрлэн манлайлж, аливаа шийдвэр гаргахдаа хувийн явцуу эрх ашиг сонирхолтойгоо хутгалгүй, авлигатай хийх тэмцлийн тэргүүн эгнээнд өөрсдөө байхгүйгээр дунд, доод шатанд албан хаагчдаас авлига авч болохгүй, ил тод бай, хүнд суртал гаргаж чирэгдүүлдэгээ больцгоо гэж шаардах нь утга учиргүй хэрэг болно.

Өнөөгийн төр, засгийн өндөрлөгт байгаа зарим авлигад хардагддаг хүмүүс эрх мэдлээ ашиглан хууль бус үйлдлүүдээ илэрч баригдахгүй дархлаагаа бий болгож чадлаа ч ардчилсан сонгуулийн хувьсгалаар албан тушаалаасаа хагацахад 1996 онд цаазлуулах ял авсан өмнөд Солонгосын Ерөнхийлөгч асан Чон Ду Хван, 22.5 жил гянданд хоригдох ял авсан Ро Дэ У, цэргийнхний хийсэн төрийн эргэлтээр зайлуулагдсан Тайландын Ерөнхий сайд асан Таксин Шинаватра нарт тохиолдсон эмгэнэлт хувь заяа манайд давтагдахгүйн баталгаа байхгүйг сануулахад илүүдэхгүй байх аа.

Ер нь төрийн алба авлигачдыг орогнуулах орон зай биш гэдгийг Авлигатай тэмцэх хараат бус байгууллага байгуулагдан ажиллаж эхэлсэн энэ цаг үед зориуд хэлэхэд илүүц болохгүй.

Жил гаруйн дараа болох УИХ-ын болон орон нутгийн сонгуулиар төр, засгийг авлигачдаас цэвэрлэхэд иргэний нийгмийнхэн оройлон оролцох болно.

Авлигатай хийх тэмцлийг амжилтад хүргэхэд хүчирхэг хөшүүрэг болдог олон түмний хяналт, эрэн сурвалжлах сэтгүүл зүйгээр олж илрүүлсэн мэдээлэлд ач холбогдол өгч, юуны түрүүнд түүнд нэр холбогдсон ажилтнуудынхаа ёс зүйтэй холбон үзэж, эрх бүхий байгуулагаас шалгах ажиллагаад хүндрэл учруулалгүй, үнэн, худлын алин болохыг олуулахын тулд аль болох дэмжлэг үзүүлэх явдал гэж үзэж байна.

Ардчилсан нийгмийн хүчилтөрөгч гэгддэг нууцад үл хамаарах мэдээллүүдийг бүх байгууллага нээлттэй болгосноор авлигад идэгдсэн гэж хардагддаг элдэв ярианаас ангид байх боломж бүрдэнэ. Ялангуяа төрийн үйлчилгээг иргэд, байгууллагад үзүүлдэг төрийн захиргааны байгууллагууд үйлчилгээнийхээ холбогдолтой бүх мэдээллийг ил тод болгох нь иргэдийг залхтал явуулдаг чирэгдэл арилж, авлигыг багасгана.

Авлигатай тэмцэх ажилд төр, засгийн нэгдсэн бодлого, чиглэлийг баримтлан ажиллах талаар анхаарлаа хандуулан ажиллах цаг хэдийн болжээ.

Иймд Улсын Их Хурлаас батлан хэрэгжүүлж байгаа Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг цаг үеийнх нь шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж хэрэгжүүлж энэхүү ажилд өргөн олны идэвх санаачилга, хүч бололцоог ашиглах бүх талын баталгаа хангахад чиглэсэн тодорхой асуудлуудыг тусгаж өгөх санал дэвшүүлж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Төсөл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007
оны ...дугаар зарлигийн хавсралт

**Авлигатай тэмцэх газрын дэргэдэх
Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ нь орон тооны бус байх ба үйл ажиллагаандаа энэхүү журмыг баримтална.

1.2. Зөвлөлийн үйл ажиллагааны зорилго нь Авлигын эсрэг хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд олон нийтийг төлөөлөн тогтмол үйл ажиллагаа явуулж, Авлигатай тэмцэх газрын ажилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, нууц хадгалах зарчмыг баримтална.

1.4. Зөвлөл нь Авлигатай тэмцэх газрын хараат бус байдал, бие даасан үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандана.

1.5. Зөвлөл нь Авлигатай тэмцэх газрын дотоод ажилд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

Хоёр. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь 15 гишүүнээс бүрдэх бөгөөд тус зөвлөл нь гүйцэтгэх чиг үүргийн дагуу дараах дэд зөвлөлүүдтэй /цаашид “Дэд зөвлөл” гэх/ байна:

2.1.1. Олон нийтийн харилцааны дэд зөвлөл,

2.1.2. Судалгаа, үнэлгээний дэд зөвлөл.

2.2. Зөвлөлийн дарга Авлигатай тэмцэх газрын даргатай зөвшилцөн Дэд зөвлөлүүдийг байгуулж, гишүүдийг Дэд зөвлөлүүдэд хуваан харъяалуулна. Дэд зөвлөлийн хурлаас ахлагчийг нэр дэвшүүлэн сонгоно.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр

3.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан /цаашид “хуралдаан” гэх/ байна.

3.2. Зөвлөлийн хуралдааныг улиралд 2-оос доошгүй удаа хийх ба гишүүдийн дийлэнх олонхи хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.3. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга болон Дэд зөвлөл санал болгоно.

3.4. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санал болгож болно.

3.5. Дэд зөвлөл нь улиралд 2-оос доошгүй удаа хуралдана.

Дөрөв. Зөвлөлийн чиг үүрэг

4.1. Зөвлөл нь Авлигын эсрэг хуульд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах талаар санал, санаачилга гарган ажиллах;

4.1.2. авлигын талаар олон нийтийн санал бодлыг Авлигатай тэмцэх газарт уламжлах;

4.1.3. авлигын нөхцөл байдлын талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах;

4.1.4. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах.

4.2. Зөвлөл нь хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар зөвлөмж гаргах ба уг зөвлөмжийг Авлигатай тэмцэх газарт өгнө.

Тав. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл

5.1. Дэд зөвлөл нь үйл ажиллагаандаа дараахь чиглэлийг баримтална.

Олон нийтийн харилцааны дэд зөвлөл:

5.1.1. олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх;

5.1.2. авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар хурал, зөвлөлгөөн, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

5.1.3. авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллагуудын болон иргэдийн сайн дурын үйл ажиллагаа, хөдөлгөөнийг Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;

5.1.4. авлигаас урьдчилан сэргийлэх талаар олон улсын байгууллага, гадаадын орон, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран нийслэл, бүс нутаг, орон нутгийн хэмжээнд төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах.

Судалгаа, үнэлгээний дэд зөвлөл:

5.2.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт болон авлигын нөхцөл байдлын талаар үнэлгээ хийж, түүнд дүгнэлт өгөх;

5.2.2. авлигын түвшин, хандлагын талаарх Авлигатай тэмцэх газрын судалгаанд санал, зөвлөмж өгөх,

5.2.3. авлигатай тэмцэх ажлын эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж гаргах;

5.2.4. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон авлигатай хамтран тэмцэх талаар байгууллага, иргэдэд хандан уриалга гаргах.

Зургаа. Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх

6.1. Зөвлөлийн дарга, гишүүн нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг баримтлан ажиллаж дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Зөвлөлийн дарга нь 6.3-т зааснаас гадна дараахь бүрэн эрхийг эдэлнэ:

6.1.1. Зөвлөлийг төлөөлж Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллага, иргэдтэй харилцах;

6.1.2. Зөвлөлийн хуралдааны товыг зарлан зохион байгуулж, удирдан явуулах;

6.1.3. Зөвлөлийн хуралдаанаас гаргасан зөвлөмжийг Авлигатай тэмцэх газрын даргад өгөх, зөвлөмжийн үндэслэлийн талаар тайлбарлах;

6.1.4. Зөвлөлийн ажлыг төлөвлөн зохион байгуулж, үйл ажиллагааны үр ашигтай байдал, үр дүнг Авлигатай тэмцэх газрын өмнө хариуцах.

6.2. Дэд зөвлөлийн ахлагч нь 6.3-т зааснаас гадна дараахь бүрэн эрхийг эдэлнэ:

6.2.1. Дэд зөвлөлийн хурлын товыг зарлан зохион байгуулж, удирдан явуулах ;

6.2.2. Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг Зөвлөлийн даргад танилцуулж зөвшөөрлийг нь авсны үндсэн дээр хуралдаанд оруулах;

6.2.3. Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хуулиар хориглосноос бусад мэдээ, мэдээллийг Авлигатай тэмцэх газраас гаргуулан авах.

6.3. Зөвлөлийн гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар өөрийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

6.3.2. энэхүү журмын 4.1-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар санал, санаачилга гаргах;

6.3.3. авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах;

6.3.4. улс төрийн нам, аливаа эвсэл, хөдөлгөөний шахалт, шаардлагад автахгүй байх;

6.3.5. хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд Зөвлөлийн хуралдаан болон Дэд зөвлөлийн хуралд оролцож байх;

6.3.6. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай холбоотой нууцалбал зохих мэдээ, мэдээллийг задруулахгүй байх.

Долоо. Авлигатай тэмцэх газрын эрх, үүрэг

7.1. Авлигатай тэмцэх газар нь Зөвлөлтэй хамтран ажиллах талаар дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1. Зөвлөлийн хуралдаан болон Дэд зөвлөлийн хурал болохоос 3 хоногийн өмнө түүний зар болон хуралдаанд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Зөвлөлийн гишүүдэд хүргэх;

7.1.2. Зөвлөлийн хуралдаан болон Дэд зөвлөлийн хурлыг явуулах байр, шаардлагатай техник хэрэгслээр хангах;

7.1.3. Зөвлөлийн хуралдаанаас гарсан, хууль тогтоомжид нийцсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч Зөвлөлд энэ талаар мэдэгдэх;

7.1.4. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай бусад туслалцаа, дэмжлэг үзүүлэх ба хууль, тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хамтран ажиллах;

7.1.5. Зөвлөлд хандан авлигатай тэмцэх тодорхой асуудлаар дэмжлэг туслалцаа хүсэх;

7.1.6. Зөвлөлийн болон Зөвлөлийн гишүүний авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагаанд харш үйлдэл, үйл ажиллагааны талаар анхааруулга өгөх;

7.1.7. хуульд өөрөөр заагаагүй бол Зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

7.1.8. Авлигатай тэмцэх газрын удирдлагын зөвлөлийн гишүүн нь Зөвлөлийн хүсэлтээр хуралдаанд оролцож тус газрын бодлого, үйл

ажиллагааны талаар тайлбар өгөх, хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар саналаа хэлэх.

**Найм. Зөвлөлийн дарга, гишүүнийг
томилох, чөлөөлөх**

8.1. Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан иргэнийг Зөвлөлийн дарга, гишүүнээр томилуулахаар Авлигатай тэмцэх газраас нэр дэвшүүлж Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.

8.2. Нэр дэвшүүлсэн иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч томилохоос татгалзвал Авлигатай тэмцэх газраас дахин нэр дэвшүүлнэ.

8.3. Зөвлөлийн дарга, гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө дараахь үндэслэлээр чөлөөлнө:

8.3.1. төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албанд сонгогдсон эсхүл томилогдсон;

8.3.2. Авлигатай тэмцэх газраас өгсөн анхааруулгыг үл харгалзан авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагаанд харш үйлдлийг удаа дараа гаргасан;

8.3.3. гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг нь шүүх нотолж шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

8.3.4. эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлүүлэх тухай хүсэлтээ өөрөө гаргасан;

8.3.5. Зөвлөлийн болон Дэд зөвлөлийн үйл ажиллагаанд хүндэтгэх шалтгаангүйгээр оролцохгүй болсон.

8.4. Зөвлөлийн дарга, гишүүнийг Авлигатай тэмцэх газрын санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч чөлөөлнө.

-----o0o-----